

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны
12 дугаар сарын 05-ны өдрийн 529
дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн
боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Хууль тогтоомжийн нэр огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо

Байгууллагын нэр:

..... аймгийн Биеийн тамир,
спортын газар

Нэгжийн нэр:

Спортын хэлтэс

Албан тушаалын нэр:

Спортын хэлтсийн дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

..... аймгийн
сумын баг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Биеийн тамир, спортын салбарын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, бодлогын шийдвэрийг Биеийн тамир спортын дээд байгууллага, аймаг орон нутгаас биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр, бодлого, чиглэл, зорилго зорилт, төлөвлөлт, стратеги төлөвлөгөө, байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, спортын хөгжлийн үр нөлөөг дээшлүүлэх, судалгаа хийх, төсөл хөтөлбөр боловсруулан хэрэгжилтийг ханган чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Биеийн тамир спортын хууль, бодлого, хөтөлбөр тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг төрийн болон орон нутгийн баримтлах бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах, тайлагнах.

2.Төр төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, тэмцээн наадмын шаталсан тогтолцоо хөгжүүлэх, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, спортын арга хэмжээний төлөвлөлт удирдлага арга зүйгээр хангах, багш дасгалжуулагч, мэргэжилтний мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж ажиллах.

3.Биеийн тамир, спортын тухай хууль түүнд нийцүүлэн уралдаан тэмцээн зохион байгуулах, спортын ажил үйлчилгээг үр дүнд суурилж, төлөвлөх, аймгийн шигшээ баг бүрдүүлэх эрх зүйн орчин бий болгох тамирчдыг бүс, улсын тэмцээнд амжилттай оролцуулах, секц дугуйлангийн үйл ажиллагааг тогтмолжуулах, клубуудыг удирдлага арга зүйгээр хангах ажиллах.

4.Салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, нэгжийн чиг үүргийг удирдан зохион байгуулах, хянах тавих, тайлагнах.

5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх - Г Хянах -Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж, бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан, шийдвэр, хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, гүйцэтгэлт хяналт тавих, үр дүнг тайлагнах.	Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан байна.	Г,Х
	2.Засгийн газар болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэн гүйцэтгэлт хяналт тавих, үр дүнг тайлагнах.	Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан байна.	Г,Х
	3.Орон нутгийн спортын хөгжүүлэх бодлого, төлөвлөлт боловсруулах, судалгаа дүн шинжилгээ, санал дүгнэлт гаргаж, оновчтой тогтолцоог сайжруулах.	Биеийн тамир, спортын эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилт хангагдсан байна.	Г,Х



2 дугаар зорилтын хүрээнд	1.Төр, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, тэмцээн наадмын шаталсан тогтолцоо хөгжүүлэх, орон нутгийн бүх шатны байгууллагын биеийн тамирын багш дасгалжуулагч, арга зүйч, ажилтан нартай хамтран зохион байгуулах, удирдлага арга зүйгээр хангах, хяналт тавих.	Спортыг хөгжүүлэх ажил үйлчилгээний зохион байгуулалт, чанар хүртээмж сайжирсан байна.	Г, Х
	2.Аймаг, орон нутаг дахь спортын тэмцээн наадмын хөтөлбөрт багтах спортын төрлийг тогтоох, зохион байгуулалт, үйл ажиллагаанд мэргэжил арга зүйгээр хангах, хамтран ажиллах	Аймаг орон нутагт зохион байгуулагдах спортын арга хэмжээний чанар хүртээмж дээшилсэн байна.	Г, Х
	3.Орон нутаг дахь спортын салбарын хүний нөөцийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах, чадавхжуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх.	Үйл ажиллагааны хэрэгжилт сайжирсан байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Аймаг, орон нутгийн спортын холбоодын төлөвлөлтөд спортын бодлогоор хангах, үйл ажиллагааг тусгуулах, мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангах.	Спортын бодлогын хэрэгжилт хангагдсан байна.	Г,Т
	2.Сум, байгууллага, спортын холбоодын спортын үйл ажиллагааны төлөвлөлтөд санал, зөвлөмж, дүгнэлт хүргүүлэх, хамтран ажиллах, гүйцэтгэл үр дүнг тооцох.	Бодлого төлөвлөлт сайжирсан байна.	Г,Х
	3.Аймаг, орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдах спортын наадам, тэмцээнийг орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, эдийн засгийн үр нөлөөг тооцох, арга зүйн зөвлөмж хүргүүлэх, хамтран ажиллах.	Спортын салбарт мөрдөх стандартын шаардлагад нийцсэн байна.	Г,Т
	4.Спортын наадам, тэмцээнд оролцох баг тамирчдын бэлтгэл дасгалжуулалт, шинэ тутамд хөгжиж байгаа спортын төрлийн дэмжих, хүн амын хөгжлийн	Спортын хөгжилд орон нутгийн оролцоог нэмэгдүүлсэн байна.	Г, Х



	судалгаа хийх санал дүгнэлт, гаргах, хүргүүлэх.		
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Албаны чиг үүргийн хэрэгжилтийг ханган холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, удирдлага арга зүйгээр хангах, хяналт тавих.	Чиг үүрэг хангагдсан байна.	Г,Х
	2.Засгийн газар, агентлаг, орон нутаг, төрийн болон төрийн бус байгууллагууд, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах.	Салбар хоорондын ажлын уялдаа холбоо сайжирсан байна.	Г,Т
	3.Агентлаг бусад холбогдох дээд шатны байгууллагад чиг үүрэгтэй холбоотой мэдээ тайлан, судалгааг хугацаанд нь чанартай шуурхай гаргах, хүргүүлэх.	Бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, чанарт ахиц гарсан байна.	Г
	4.Байгууллагын чанарын бодлого, зорилтуудад нийцсэн биеийн тамирын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх, удирдлагад тайлагнах.	Биеийн тамирын ажил, арга хэмжээний төлөвлөлт сайжирсан байна.	Г,Х
5 дугаар зорилтын хүрээнд	1.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж, нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах	Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан байна.	Г, Х

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	- Багш, биеийн тамирын боловсрол /011437/ - Биеийн тамирын боловсрол /011438/ -Спортын дасгалжуулагч /101401/ -Биеийн тамирын арга зүй /101402/
Мэргэшил	Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх.
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.



Ур чадвар	Дүн шинжилгээ хийх ур чадвар	<ul style="list-style-type: none"> -мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн шинжилгээ хийх; -хяналт, шинжилгээ үнэлгээ хийх, харьцуулсан судалгаа хийх; -бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулах; -албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; -судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх; -бусад.
	Асуудал шийдвэрлэх ур чадвар	<ul style="list-style-type: none"> -үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; -тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар тодорхойлох; -хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг гаргах; -аливаа харилцааг хэрэгжүүлэх арга замыг хууль тогтоомжид нийцүүлэн тодорхойлох; -бүрэн эрхийн хүрээний асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; -гаргасан шийдвэрийнхээ үр дагавар, эрсдэлийг хариуцах; -шаардлагатай асуудлаар судалгаа хийж, нэгтгэн дүгнэх; -бусад.
	Манлайлах ур чадвар	<ul style="list-style-type: none"> -ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх; -нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх, өөрчлөлтийг хийхдээ урьдчилан тооцоолох, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих; -байгууллага, нэгжийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; -гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа хамт олны саналыг тусгах; -бусад.
	Бусад ур чадвар	<ul style="list-style-type: none"> -хүний эрхийн стандартуудыг хэрэгжүүлэх; -англи хэл эсхүл, бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; -кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; -компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах, мэдээллийг шуурхай хүргэх; -албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; -хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ



Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

..... аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын газар, хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс
- Төрийн бус байгууллага;
- Иргэн, хуулийн этгээд мэргэжлийн байгууллага.
- Сум

У.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

..... О.ГЭРЭЛ

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 23.12.05

Дугаар: 529

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

..... АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ДАРГА /

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

